

**“СОР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 3 сарын 18-ны өдөр

№26/ *002*

Улаанбаатар хот

**Г ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ Г**

“Компанийн тухай” хуулийн 60 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4, 67 дугаар зүйлийн 67.1, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, ТУЗ-ийн шийдвэрийг тус тус үндэслэн

ТОГТООХ НЬ :

1. “Сор” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 27-ны өдрийн 10.00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Чингисийн өргөн чөлөө, компанийн өөрийн байрны хурлын танхимд хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.2. Ногдол ашгийн талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
 - 2.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улираан томилох;
 - 2.4. Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2026 оны төсөв батлах ;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2026 оны 4-р сарын 8-ны** өдрөөр тогтоосугай.
4. Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг нэгдүгээр хавсралтаар баталж, **2026 оны 3 дугаар сарын 20-ны** өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо болон “Монголын хөрөнгийн бирж”-д хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталж **2026 оны 3 дугаар сарын 23-ны** өдөр “Монголын хөрөнгийн бирж” болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонингоор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн уг зарыг **2026 оны 4 дугаар сарын 8-ны** өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зар хүргэхээр тогтсугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдахыг “СОР”ХК-ийн ТУЗ-ийн гишүүн Ишхүү овогтой И.Дариймаад даалгаж, зохион байгуулах Комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Комиссын дарга:

Д.Байгальмаа- ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

Д.Ганчимэг –“Блю скай кашемир”ХХК-ийн хүний

нөөцийн мэргэжилтэн

6. Хурлын Тооллогын комиссыг гуравдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
7. Санал хураах хуудасны загвар, агуулгыг тавдугаар хавсралтаар баталж, санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу **2026 оны 4-р сарын 27-ны өдрийн 14.00** цагаар тогтоосугай.
8. Хурал зохион байгуулах комисс /Д.Байгальмаа/-д:

8.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг **2026 оны 3 дугаар сарын 28-ны** дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанид цахим хэлбэрээр хүргүүлэх,

8.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг заасан хугацаанд хууль, журамд нийцүүлэн зохион байгуулахыг тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



С.Б.ГРОМОВ